

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2022/148/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Булган аймаг 2022 он	хуудас:	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: З.Ганбаатар Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn
--	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2021-02-25 № 92
танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.МӨНХТУЯА
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot


006020156

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	35.1	46.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	42.7	449.5
	Нийт хөрөнгийн дүн	77.7	495.9
	Нийт өр төлбөрийн дүн	6.0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	71.7	495.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	77.7	495.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	205.1	606.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	186.0	180.1
	Үйл ажиллагааны үр дүн	19.1	426.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	2.2
	Үйл ажиллагааны нийт үр дүн	0	424.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	66.4	71.7
	Тайлант оны үр дүн	5.3	424.3
	Эцсийн үлдэгдэл	71.7	495.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	197.1	191.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	181.9	191.3
	Үйл ажиллагааны ЦМГ	15.1	0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	1.4	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	13.8	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	191.1	177.4
	Урсгал зардал	191.1	177.4
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45.4	45.4
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145.7	145.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зорилго: СӨНХүүхдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлж, хүүхдийн цэгц хөгжлийг хангах, тэднийг хайрлан хүндэтгэж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэн, харилцааны соёлыг эрхэмлэсэн хамт олон болно. Олон тулгуурт хөгжлийн загварыг хэрэгжүүлж, эдийн засгийн бие даасан байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжсэн, иргэнээ дээдэлсэн аймаг болохыг зорино. Зорилтууд: Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Ил тод байдлыг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг хөгжүүлнэ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 7.1 хувиар буюу 13,704.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 758.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 758.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд 758,100.0 төгрөгийн хүнсний материалыг дутагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, 6.4.1 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй./149-6/

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлангийн иж бүрдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдлийг бүрдүүлж хавсаргаагүй, төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдэл бүрэлдэхүүн хэсгийн дагуу тайлангаа ирүүлээгүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1										
1	ТШЗ	3	0.8	0	0	1	0.8	1	0	1	0
	НИЙТ	3	0.8	0	0	1	0.8	1	0	1	0